



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/278

Хэрлэн сум

Тоног төхөөрөмж худалдан авахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар сарын 09-ний "Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" арван наймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн архивыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, мэдээллийн эргэлтийн санг нэмэгдүүлэхэд зориулан 19,687,200 (арван есөн сая зургаан зуун наян долоон мянга хоёр зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын-ны өдрийн
..... дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгийн зарцуулалтын тооцоо

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өнгөт хэвлэгч Bizhub C300i	1	19687200	19687200
Нийт дүн				19687200